



“ЗАМ,ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

2025 ОН




Товч танилцуулга

- **“Зам, тээврийн хөгжлийн төв”** төрийн өмчит үйлдвэрийн газар нь “Авто замын хууль тогтоомж, салбарын бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын чанар, аюулгүй байдал, ашиглалтын хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, замын сүлжээг хөгжүүлэх, салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, зам, замын байгууламжийн зураг төслийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын болон улсын чанартай авто зам ашигласны төлбөр авах нэгжийн үйл ажиллагааг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, салбарын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа” –г хэрэгжүүлэн ажиллаж байна.
- **Эрхэм зорилго:** Монгол улсын авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, арчлалт, засварын ажлыг удирдан зохион байгуулах, зам тээврийн чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх, стандарт, норм нормативын баримт бичиг боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төслийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын техник технологийн хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.
- **Бүтэц зохион байгуулалт:** Монгол улсын Засгийн газрын 2015 онд 02 дугаар сарын 09-ний өдрийн 55 дугаар тогтоолоор “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нэртэйгээр тус тус шинэчлэн зохион байгуулагдсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан дүрэм, 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 643 дугаар тогтоолын дагуу 7 хэлтэс, 1 алба, үндсэн 120 гэрээт 290, нийт 410 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.



“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР



Үндсэн ажилтан – 120 Гэрээт ажилтан – 290 Нийт - 410



Зорилтот түвшин төлөвлөгөө, IV улиралын гүйцэтгэл-хураангуй-2025

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
1	Нийт орлого	9,063,085,013.00	17,923,892,949.00	10,984,567,652.81	-6,939,325,296.19	61%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	8,842,943,953.00	17,923,892,949.00	10,774,206,760.77	-7,149,686,188.23	60%
2	Нийт зардал	8,851,541,589.00	17,507,559,039.00	10,416,462,356.71	-7,091,096,682.29	59%
	Татварын өмнөх ашиг/алдагдал	211,543,424.00	416,333,910.00	571,105,296.10	154,771,386.10	137%
	Орлогын албан татвар	21,154,342.40	41,633,391.00	57,110,529.61	15,477,138.61	137%
3	Цэвэр ашиг, алдагдал	190,389,081.60	314,700,519.00	513,994,766.49	199,294,247.49	163%

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн 245 тоот тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийж баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 17,923,892,949.00 төгрөгөөр, нийт зардлыг 17,507,559,039.00 төгрөгөөр, 314,700,519.00 төгрөгийн ашиг / алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.
- Тайлант онд 10,984,567,652.81 төгрөгийн орлого олж 10,416,462,356.71 төгрөгийн зардал гаргаж 513,994,766.49 төгрөгийн татварын дараах ашигтай ажиллаж ашгийн төлөвлөгөөг 163 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтын зардал, арга хэмжээний төлөвлөгөөгөөр 82,227,272 төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.



**Зам, тээврийн сайдтай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд
7 бүлэг 84 ажил төлөвлөн ажиллаж байна.**





“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БАРИЛГА

1 ДҮГЭЭР БАЙР



Засгийн газрын 2018 оны 112 дугаар тогтоолоор татан буугдсан “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн эзэмшилд байсан 512 мкв 2 давхар оффиссын барилгыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр шилжүүлэн авч, Захирал, Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтэс, Дотоод аудитын алба тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ: МАНАЙ БАЙГУУЛЛАГЫН БАЙРНУУДЫН ХУВЬД ТӨВИЙН ШУГАМД ХОЛБОГДООГҮЙ, БОХИРОО ӨӨРСДӨӨ СОРУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА. ЭНЭ НЬ БОХИР СОРСОН ӨДРҮҮДЭД АГААРТ БОХИР ТАРХАХ АСУУДАЛ БАЙГАА БӨГӨӨД ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУВЬД МАШ ХОРТОЙ НӨХЦӨЛД БАЙНА.

2 ДУГААР БАЙР



1985 онд 1 давхар барилга ашиглалтад орж, 2005-2006 онуудад 2 давхар болгон өргөтгөсөн. Уг барилга нь одоогоор 2 давхар 510.92 мкв талбайтай, 15 өрөөтэйгээр, Авто замын төв лаборатори, Барилга, угсралтын хяналтын хэлтэс, Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс, Авто замын ашиглалтын хэлтэс, Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтэс тус тус үйл ажиллагаа явуулж байна.

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ



“Ай ди си проперти” ХХК-тай түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй барилгын ажлыг бүрэн дуусган ашиглалтад оруулах гэрээ байгуулсан. Гэрээний үүргийн биелэлт хангагдаагүйгээс гэрээг цуцлах нөхцөл байдал үүсч, нийт хоёр удаагийн гүйцэтгэлийн 1,372,086,747 төгрөгийн санхүүжилтийг олгож, 72,2% хувийн гүйцэтгэлтэйгээр барилгын ажил зогссон. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Барилгын ажилтай холбоотой баримт бичгийг бүрдүүлж, ажил эхлүүлэх үеийн бэлтгэл ажлыг хангаж, холбогдох 11 байгууллагуудруу техникийн нөхцөл, Улсын байцаагчийн дүгнэлт, Захиалагчийн хяналтын дүгнэлт, Барилгын ашиглалт хангах эсэх дүгнэлт, Барилгын ажлын зураг шинээр зуруулах, Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах зэрэг албан тоотыг хүргүүлэн ажилласан.



АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САН

ЗОРИЛГО: “АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САН” нь Авто зам, замын байгууламжийн стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх судалгааны ажлыг санхүүжүүлэх зорилго бүхий сан.

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН /хуучин нэрээр/ 2018 ОНЫ 142 ДУГААР ТУШААЛ

- Авто замын норм нормативын сангийн ажиллах журам”-ын шинэчилсэн төслийг сайжруулах ажилд “Монгол өмгөөлөгч” хуулийн зөвлөх компанитай хамтран 2025 оны 08 дугаар сарын 29 болон 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд уулзалт хийж, журмын төсөлд мэргэжлийн санал, зөвлөмжийг авч журмын төслийг эцэслэн боловсруулан ажилласан.
- Зам тээврийн сайдын ухаан технологийн зөвлөлийн дэргэдэх 2024 оны А/106 дугаар тушаалаар байгуулагдсан Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дэргэдэх Авто замын салбарын Шинжлэх ухаан технологийн дэд зөвлөлийн 2025 онд зохион байгуулагдсан нийт 12 удаагийн хуралд 30 асуудлыг хэлэлцүүлж, зөвлөмжийг гарган байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.



ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР 2025-2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТ 87 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 3.811.124.406 ТӨГРӨГИЙН ӨРТӨГ БҮХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН.

Төрөл	Он дамжин хэрэгжих	Шинээр хэрэгжих
Стандарт	11	13
Норм дүрэм	25	9
Цахимжуулах ажил	2	4
Судалгаа	7	6
Үйл ажиллагааны зардал	10	
	45	32
Нийт 87 төсөл арга хэмжээ		

2025-2026 онд он дамжсан болон шинээр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ

Үр дүн:

Бүрэн хэрэгжсэн – 11 /8 стандарт, 2 норм, 1 судалгаа/
Батлагдах шатанд – 9 /норм, гарын авлага/
Дуусах-1 /норм/
Хэрэгжиж буй – Эцсийн болон Дунд шатанд- 29 /15-норм, 4 стандарт, 8 судалгаа, 2 цахимжуулах/
Эхлэлийн шатанд- 8
Тендерийн шатанд- 18
Хэрэгжүүлэх шаардлагагүй- 1 /судалгаа/

ЗЗБНБД 81-013-2019 “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм”, “Авто зам, замын байгууламж, гүүр барих нормативт хугацаа, авто зам, гүүрийн барилга засварын ажлын үе шатны ажлуудад ноогдох ИТА-ын цагийн томсгосон норм”-ыг шинэчлэн боловсруулах -ыг шинэчлэн боловсруулж холбогдох хурлаар дэмжигдсэн.



1. Зураг төслийн магадлал

2025 онд

Нийт 404 зураг төсөл



349 зураг төсөл

2838.4 км



29 зураг төсөл

2565,6 у/м



1 зураг төсөл

2.2 км

1.1 Төмөр замын Зураг төслийн магадлал



трам-2 ТЭЗҮ-ийн тайлан

26.2 км

төмөр зам-23 зураг төсөл

135,9 км

Авто зам, гүүрийн магадлашгүй ажлын төсөв -15

2025 оны 4 дугаар улирлын байдлаар зураг төслийн магадлалын үйл ажиллагаанаас **2,989,592,120** төгрөгийн орлогыг төвлөрүүлж, экспертийн цалингийн зардалд **1,883,443,036** төгрөг, төвийн үйл ажиллагааны зардалд **807,189,872** төгрөг, НӨАТ-ын төлбөрт **298, 959, 212** төгрөг тус тус зарцуулаад байна.

1.2 Зураг төслийн нэгдсэн цахим архив

- Зураг төслийн баримт бичигт 2015-2025 оны хугацаанд **2888** магадлалын ерөнхий дүгнэлт гарган магадлалын зураг төслийн баримт бичгийн мэдээллийг 72% гүйцэтгэлтэй серверт хуулж архивын нэгж үүсгээд байна.
- Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем **/PIMIS/-**д 2025 оны нийт **404** магадлалын ерөнхий дүгнэлтийг оруулсан
- 2007-2015 оны хооронд хийгдсэн авто замын зураг төслийн **674** магадлалын ерөнхий дүгнэлт цаасаар хүлээж авсан бөгөөд дүгнэлтүүдийг цахим хэлбэрээр бэлтгэн нэгдсэн цахим мэдээллийн санд оруулсан.

Цахимжуулалт



www.roadestimator.mn



<https://www.magadlal.rtdc.gov.mn/>



<https://www.norm.rtdc.gov.mn/norm/>



БАРИЛГА УГСРАЛТЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2017 онд батлагдсан Авто замын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын 11 дүгээр зүйлийн 1.12-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн техник технологийн хяналтыг захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Авто зам, замын байгууламжийн барилга засварын ажлын чанар, аюулгүй байдал, ашиглалтын найдвартай нөхцөлийг хангах бодлогыг хэрэгжүүлэх;
- Хэлтсийн хүний нөөцийг чадавхижуулж, ур чадвар, ажлын бүтээмжийг сайжруулан мэргэшсэн инженерийн баг бүрдүүлэх
- Төвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Улсын төсөв болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн захиалагчийн хяналтын зардлаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг биелүүлэн ажиллана



БАРИЛГА УГСРАЛТЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга угсралтын хяналтын хэлтэс нь он дамжин хэрэгжиж буй 23 авто зам, 2025 онд шинээр Зам, тээврийн сайдын А/52, А/199 дугаартай тушаалуудаар 2 төсөл арга хэмжээний эрх нь шилжин ирж, Зам, тээврийн яамтай техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж байна. Нийт 25 авто зам, гүүрийн барилга угсралтын ажил дээр захиалагчтай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан хоёр төслийн гэрээг доор харуулав.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ӨМЧИТ БИЧГИЙН
ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧ:
“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

ХУ.1.1.1.8 АЙМГИЙН ТӨВИЙН ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМЫН ҮРГЭЛЖЛЭЛ,
19.6.2025 ОНЫ ДАГААР 2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН 21-НИЙ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2025 оны 01 сарын 21 өдөр Дугаар УТ2402804346/1 Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн яам (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь дараах зүйлийг харилцан тохиролцож, Зам, тээврийн Сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/52 дугаар тушаалыг үндэслэл болгон энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь 238,775,981.00 (хоёр зуун гучин найман сая долоон зуун далан таван мянга есөн зуун наян нэг) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын харилцах Богд банкны 57003800 8140000747 дугаар дансанд шилжүүлнэ.

3. Гүйцэтгэгч нь үйлчилгээг авто замын байгууламжийн барилгын ажилд гүйцэтгэгчийн гэрээт хугацаа дуусах хүртэл техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлэх ба улсын комисс хүлээн авсан хугацаанаас хойш баталгаат засварын хугацаа дуусах хүртэл хугацаанд хяналтыг хэрэгжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

1. Зам, тээврийн сайдын 2025 оны А/52 дугаар “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал,
2. Гэрээний тусгай нөхцөл,
3. Гэрээний ерөнхий нөхцөл,
4. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих авто замын барилгын ажилд техник технологийн зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлэх жишиг ажлын даалгавар”
5. Ажил гүйцэтгэх хуваарь.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИЛАГЧНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧ:
“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ОЮУНБОЛД

Х.2.1.1.8 БНСУ-ЫН ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БҮЙ “ГАЛТ
ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВИЙН БАРИЛГЫГ
БАРЬЖ БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР
МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ
САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН МОНГОЛЫН ТАЛЫН ХӨРӨНГӨ /УЛААНБААТАР/
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД: “ХӨСӨГ ТРЕЙД ХХК-ИЙН БАЙРНЫ УРД
ТАЛЫН АВТО ЗАМААС “ЗТХТ” ТӨҮГ-ЫН БАЙР ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН АЖИЛ”-
ЫН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2025 оны 02 сарын 09 өдөр Дугаар УТ2101101137008/201-1 Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн яам (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь дараах зүйлийг харилцан тохиролцож, Зам, тээврийн Сайдын 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/199 дугаар тушаалыг үндэслэл болгон энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь 16,453,422 (арван зургаан сая дөрвөн зуун тавин зурван мянга дөрвөн зуун хорин хоёр) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын харилцах Богд банкны 57003800 8140000747 дугаар дансанд шилжүүлнэ.


3. Гүйцэтгэгч нь үйлчилгээг авто замын байгууламжийн барилгын ажилд гүйцэтгэгчийн гэрээт хугацаа дуусах хүртэл захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлэх ба улсын комисс хүлээн авсан хугацаанаас хойш баталгаат засварын хугацаа дуусах хүртэл хугацаанд хяналтыг хэрэгжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 4.1. Зам, тээврийн сайдын 2025 оны А/199 дугаар “Захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх тухай” тушаал,
- 4.2. Гэрээний тусгай нөхцөл,
- 4.3. Гэрээний ерөнхий нөхцөл,



“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга угсралтын хяналтын хэлтэс нь 2025 онд Зам, тээврийн яамтай 25 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулан техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн ажилласан. Эдгээр төсөл арга хэмжээний барилгын ажлын талбай дээр 41 хяналтын инженерүүд батлагдсан зураг, төсөв, техникийн шаардлага, норм дүрмийн дагуу хяналт тавин ажилласан.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 25 төсөл арга хэмжээн дээр 41 хяналтын инженер дундажаар 7-8 сар буюу 328 хүн/сар ажилласан байна.



БАРИЛГА УГСРАЛТЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Зам, тээврийн яамтай, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-нь техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж буй авто зам, гүүрийн барилга угсралтын 2025 оны нийт ажлууд

Д/д	Гэрээний төслүүд	Гэрээний дугаар	Гүйцэтгэгч
1	Ховд Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто зам	2022.04.22 №145	“Хотгор зам” ХХК, “Жол” ХХК-ийн түншлэл
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 10 км /Говь-Алтай, Есөнбулаг/	2022.04.22 №147	“Түмдэлгэрэх” ХХК, “Хотгор зам” ХХК-ийн түншлэл
3	Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай зам	2022.10.07 №294, 2023.06.29 №199	“Мотор сервис” ХХК, “Өндөрсант Хайрхан” ХХК-ийн түншлэл
4	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 31.08км хатуу хучилттай зам	2022.09.23 №279, 2024.10.07, №438	“РЭС” ХХК
5	Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/	2022.04.22 №146, 2024.07.19 №351	“Ди Вай Кей Би” ХХК
6		2022.09.23 №280	“Туулын гүүр далай” ХХК, “Үри констек” ХХК-ийн түншлэл
7		2022.08.10 №244	“Билэгт зам” ХХК
8		2022.08.10 №243, 2024.05.13 №224	“Үйлсийн зам” ХХК
9	Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто зам	2022.08.12 №268, 2023.06.29 №197	"Монгол зам групп" ХХК, "Голд Өлзийт" ХХК-ийн түншлэл
10	Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км авто замын багц 2 дүгээр хэсгийн 62 км хатуу хучилттай авто зам	2022.07.04, №217	"Мотор сервис" ХХК
11	Хөвсгөл аймгийн Тариалан сумын 8.7 км буюу багц 2, 6.3 км хатуу хучилттай авто зам	2022.06.30 №205	"Хөвсгөл зам" ХХК
12	Увс аймгийн Улаангом сумын Баруун тойруугийн авто замын шинэчлэлт	2024.05.30 №252	"Жол" ХХК
13	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвийн 4.48 км хатуу хучилттай авто зам	2024.05.30 №250	"Жол" ХХК
14	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвийн 2.5 км хатуу хучилттай авто зам	2024.06.18 №307	"Гранд рөүд" ХХК



Д/д	Гэрээний төслүүд	Гэрээний дугаар	Гүйцэтгэгч
15	Булган аймгийн Хишиг-Өндөр сумын төвийн 4.2 км хатуу хучилттай авто зам	2024.05.30 №251	“Эвт-Уул” ХХК
16	Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн хатуу хучилттай авто зам ПК118+600-ПК127+200 буюу 8.6 км	2024.09.30 №436	“Идэр ширэгү” ХХК
17	Хамарын хийдийн авто замаас Зүүнбаян чиглэлийн 12 км хатуу хучилттай авто зам	2024.10.15 №441	“Борхойн зам” ХХК
18	Баян-Уул-Ульхан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын багц-1 буюу 24 км авто зам	2023.11.15 №372	Билэгт зам ХХК, "Нано экологи" ХХК-ний түншлэл
19	Баян-Уул-Ульхан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын багц-2 буюу 26 км авто зам	2023.11.10 №367	"Дашин" ХХК
20	Чойбалсан-Хавирга чиглэлийн 124.5 км авто замын багц-1 буюу 31 км хатуу хучилттай авто зам	2024.05.03 №211	“ЗБИБ” ХХК, “ЗЗБ” ХХК-ний түншлэл
21	Чойбалсан-Хавирга чиглэлийн 124.5 км авто замын багц-2 буюу 31 км хатуу хучилттай авто зам	2023.11.10 №368	"Анандын зам" ХХК
22	Чойбалсан-Хавирга чиглэлийн 124.5 км авто замын багц-3 буюу 30 км хатуу хучилттай авто зам	2023.11.10 №366	"Рун Хэ Жү Жөү констракшн инженеринг" ХХК
23	Чойбалсан-Хавирга чиглэлийн 124.5 км авто замын багц-4 буюу 30 км хатуу хучилттай авто зам	2023.11.15 №371	Их монгол барилга ХХК

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-нь Зам, тээврийн яамтай 2025 онд техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний 2 төсөл арга хэмжээний гэрээ байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Д/д	Гэрээний төслүүд	Гэрээний дугаар	Гүйцэтгэгч
24	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 15.6 км /Говь-Алтай, Есөнбулаг/	2025.04.28 №УТ2402804346/108	“Бумбат даваа” ХХК
25	Х.2.1.1.8 БНСУ-ЫН тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгыг барьж байгуулах, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар монгол улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах төсөл”-ийн монголын талын хөрөнгө /улаанбаатар/ төсөл, арга хэмжээний хүрээнд: “хөсөг трейд ххк-ийн байрны урд талын авто замаас "этхт" төүг-ын байр хүртэлх авто замын ажил”	2025.07.02 УТ2101101137008/185	“Аасгалдай” ХХК




“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга угсралтын хяналтын хэлтэс нь 2025 онд Зам, тээврийн яамтай 25 төсөл арга хэмжээ нь дээр гэрээ байгуулан техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн ажилласан. Техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу эдгээр төсөл арга хэмжээний мэдээ, тайланг хуваарийн дагуу тогтмол авч захиалагчид хүргүүлж ажилласан.

Д/д	Мэдээ өгсөн сар	Мэдээ өгсөн тоо	Д/д	Тайлан өгсөн сар	Тайлан өгсөн тоо	Д/д	Гүйцэтгэл өгсөн сар	Гүйцэтгэлийн тоо
1	1 дүгээр сар	0	1	1 дүгээр сар	0	1	1 дүгээр сар	3
2	2 дугаар сар	0	2	2 дугаар сар	0	2	2 дугаар сар	4
3	3 дугаар сар	0 удаа	3	3 дугаар сар	0	3	3 дугаар сар	2
4	4 дүгээр сар	1 удаа	4	4 дүгээр сар	10	4	4 дүгээр сар	1
5	5 дугаар сар	5 удаа	5	5 дугаар сар	17	5	5 дугаар сар	6
6	6 дугаар сар	4 удаа	6	6 дугаар сар	22	6	6 дугаар сар	14
7	7 дугаар сар	4 удаа	7	7 дугаар сар	23	7	7 дугаар сар	12
8	8 дугаар сар	5 удаа	8	8 дугаар сар	23	8	8 дугаар сар	9
9	9 дүгээр сар	4 удаа	9	9 дүгээр сар	25	9	9 дүгээр сар	11
10	10 дугаар сар	5 удаа	10	10 дугаар сар	21	10	10 дугаар сар	18
11	11 дүгээр сар	3 удаа	11	11 дүгээр сар	21	11	11 дүгээр сар	5
12	12 дугаар сар	0 удаа	12	12 дугаар сар	0	12	12 дугаар сар	0
Нийт өгсөн мэдээний тоо		31 удаа	Нийт тайлан өгсөн тоо		162	Нийт гүйцэтгэл өгсөн тоо		85



“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга угсралтын хяналтын хэлтэс нь 2025 онд 25 төсөл арга хэмжээний техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр төсөл арга хэмжээний барилгын ажлын талбай дээр 41 хяналтын инженерүүд батлагдсан зураг, төсөв, техникийн шаардлага, норм дүрэм, журмын дагуу хяналт хэрэгжүүлж байна.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
2025 онд хэрэгжсэн авто зам, гүүрийн
мэдээлэл**





Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 50 км авто замын газар шорооны ажил хийгдэж байна.



Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км авто замын газар шорооны ажил хийгдэж байна.



Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто замын багц-1 буюу 68.6 км замын 2 дахь хэсгийн хучилт хийгдсэн байгаа нь.



Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 50 км авто замын газар шорооны ажил хийгдэж байна.



Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км авто замын барилгын ажлын үед анхаар тэмдэг байрлуулсан байна.



Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян чиглэлийн 12 км хатуу хучилттай авто зам барилгын ажил дуусаж хүлээлгэн өгсөн.




Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 2024 он, 2025 онд Улсын байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төслийн нэр	Хүчин чадал	Гүйцэтгэгч	Гэрээний хугацаа	Ажлын явц	Тайлбар
1	Ховд Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто зам	56.9 км	“Хотгор зам” ХХК, “Жол” ХХК-ийн түншлэл	2022-2025.12.15	100%	2024 оны 06/03/24 дугаартай ажлын хэсгийн дүгнэлт, 2025 оны 06/06/25 дугаартай ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
2	Хамарын хийдийн авто замаас Зүүнбаян чиглэлийн 12 км хатуу хучилттай авто зам	12.0 км	“Борхойн зам” ХХК	2024-2025.11.17	100%	2025 оны 10 дугаар сарын 27-ний өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
3	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвийн 2.5 км хатуу хучилттай авто зам	2.5 км	"Гранд рөүд" ХХК	2024-2025.10.31	100%	2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
4	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвийн 4.48 км хатуу хучилттай авто зам	1.8 км	"Жол" ХХК	2024-2025.10.30	42.7%	2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн 1.8 км замыг хэсэгчлэн байнгын ашиглалтад оруулсан.
5	Увс аймгийн Улаангом сумын Баруун тойруугийн авто замын шинэчлэл	3.1 км	“Жол” ХХК	2024-2025.11.15	100%	2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан. 2025.12.11-ны өдрийн 09/10/2025 дугаартай ажлын хэсгийн дүгнэлтээр баталгаажсан.
6	Хөвсгөл аймгийн Тариалан сумын 8.7 км замын багц-2 буюу 6.3 км хатуу хучилттай авто зам	6.3 км	“Хөвсгөл зам” ХХК	2021-2025.12.15	100%	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
7	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сумын 31.08 км хатуу хучилттай авто зам	20 км	“Рэс” ХХК	2022-2025.12.15	83%	2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн 20 км замыг хэсэгчлэн байнгын ашиглалтад оруулсан.
8	Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сумын 8.6 км хатуу хучилттай авто зам	8.6 км	“Идэр ширэгү” ХХК	2024-2025.12.15	100%	2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
9	Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км замын багц-2 буюу 62 км зам	42 км	“Мотор сервис” ХХК	2022-2025.12.30	100%	2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
10	Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай авто зам	49 км	“Мотор сервис” ХХК	2022-2025.12.30	100%	2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.
11	Хөсөг трейд ХХК-ийн уулзвараас ЗТХТ хүртэлх 0.5 км хатуу хучилттай авто зам	0.5 км	“Аасгалдай” ХХК	2025-2025.12.30	100%	2025 оны 11 дугаар сарын 27-ны өдөр ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулсан.




Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 2025 онд Улсын байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн онцлох төсөл, арга хэмжээ

Ховд Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто замыг хүлээлгэн өгсөн.



Хамарын хийдийн гурван замын уулзвараас Зүүнбаян чиглэлийн 12 км хатуу хучилттай авто замыг хэсэгчлэн хүлээлгэн өгсөн.



Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4.4 км хатуу хучилттай авто замыг 1.8 км хэсэгчилж хүлээлгэн өгсөн.



Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 2.5 км хатуу хучилттай авто замыг хүлээлгэн өгсөн.



2024/09/30
Ховд-Алтай чиглэлийн замаас Чандмань сум хүртэлх 56.9км хатуу хучилттай авто зам
Асфальтбетон хучилт
ПК39+860-ПК40+000




Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 2025 онд Улсын байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх бэлэн болсон ажлууд

Увс аймгийн Улаангом сум, Баруун тойруугийн 3.1 км хатуу хучилттай авто зам хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.



Булган-Орхон-Хишиг-Өндөө-Гурванбулаг чиглэлийн 133.7 км авто замын авто замын үргэлжиллэл 8.6 км хатуу хучилттай авто зам хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.



Хөвсгөл аймгийн Тариалан сумын 6.3 хатуу хучилттай авто зам хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.



Орхон-Хишиг-Өндөө-Гурванбулаг чиглэлийн 133.7 км авто замын авто замын үргэлжиллэл 31.08 км хатуу хучилттай авто зам хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.



Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км авто замын багц-2 62 км хатуу хучилттай авто зам хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.



Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай авто замыг хэсэгчлэн хүлээлгэн өгөхөд бэлэн болсон








Урсгал засварын ажил

Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/289 тушаалаар батлагдсан “Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор арчлалт урсгал засварын 42,585,405,747 төгрөгийн ажилд газар дээр нь техник технологийн хяналт тавьж, заавар зөвлөмж өгч 42,585,405,747 төгрөгний ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан ажиллав.

Ажлын гүйцэтгэл гүйцэтгэл



АВТО ЗАМЫН УРСГАЛ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ







2025

Зам, тээврийн сайдын А/156 дугаартай Арчлалт, урсгал засварын ажил хийгдэх замын чиглэл, байршил, зарцуулах хөрөнгийн хэмжээ батлах тухай” батлагдсан тушаалын дагуу 7-н байршилд хийгдэж буй 18,567,054,297 төгрөгийн ажилд газар дээр нь техник технологийн хяналт тавьж, заавар зөвлөмж өгч 18,372,489,493 төгрөгний ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан ажиллав.


Хөрөнгийн ангилал	Хөрөнгийн дүн
Батлагдсан хөрөнгө	18,567,054,298
Баталгаажсан гүйцэтгэл	18,372,489,493
Талбай дээрх ажлын гүйцэтгэл	18,099,018,262
Үлдэгдэл	468,035,952





ҮЕРИЙН УЛМААС ҮҮССЭН ГЭНЭТИЙН ЭВДРЭЛИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 онд Архангай, Өмнөговь, Дорнод Говь-Алтай аймагт орсон нутаг орсон хүчтэй аадар борооны улмаас авто зам замын байгууламжид гарсан эвдрэлийг засварлах ажилд техник технологийн хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулан ажилласан.





АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИД ҮҮССЭН ГЭНЭТИЙН ЭВДРЭЛ СААТЛЫГ АРИЛГАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛ

Зам, тээврийн сайдын 2025 оны А/285 дугаар тушаалаар батлагдсан “Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын төлөвлөгөө”-нд авто зам, замын байгууламжид үүссэн гэнэтийн эвдрэл саатлыг арилгах, сэргээн засварлах ажилд 3,988,490,000 төгрөгийн хөрөнгө батлагдсан. 4,746,179,517 төгрөгний гүйцэтгэлийг хянан баталгаажуулан ЗТЯ-руу хүргүүлэн ажилласан.






ЗӨӨВРИЙН ПҮҮГЭЭР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Улсын чанартай А0101 дугаартай Улаанбаатар–Багахангай, А0501 дугаартай Улаанбаатар–Багануур чиглэлийн авто замд “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025 стандарт болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 222 дугаар тогтоол “Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашиглан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн задрах боломжгүй ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ”-ийн дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “ болон Тээврийн Цагдаагийн албаны хамтарсан ажлын хэсэг газар дээр нь хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэв.

Улсын чанартай А0101 дугаартай Улаанбаатар-Багахангай А0501 Улаанбаатар-Өндөрхаан чиглэлд нийт 252 том оврын тээврийн хэрэгслийн даацын хяналт шалгалтыг явуулахад 192 тээврийн хэрэгсэл даац хэтрүүлсэн зөрчил илэрсэн.



Замын Дугаар	Замын чиглэл	Ажилласан хугацаа	Хяналт шалгалт хийсэн	Даац хэтрээгүй	Даац Хэтэрсэн	Хувь %
A0101	Улаанбаатар-Багахангай	5 хоног	140	48	92	34.3%
A0501	Улаанбаатар-Багануур	5 хоног	112	12	100	10.7%
НИЙТ		10 хоног	252	60	192	23.8%



2003, 2006, 2010, 2014, 2016, 2020, 2024 онд Үндэсний итгэмжлэлийн төвөөр итгэмжлэгдсэн авто замын салбарын ууган лаборатори юм.

ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨРЛҮҮД

Физик – механик шинжилгээ

- Хайрга, дайрга
- Хөрс далан суурийн материал
- Элс /буталсан чулууны элс 0-5мм/
- Эрдэс нунтаг
- Битум
- Цемент
- Хөрс бэхжүүлэх
- Асфальтбетон орц
- Цементбетон орц
- Буталсан чулуун суурийн орц


Химийн шинжилгээ

- Усны шинжилгээ
- Эрдэс нунтаг
- Элс /Эквивалент/
- Битум /Уусах чанар/

Нийт 11 төрлийн дээжинд 104 ширхэг үзүүлэлтүүдийг MNS, AASHTO, ASTM зэрэг стандартын дагуу шинжилж, дүгнэлт гарган ажиллаж байна.




СОРИЛТ ТУРШИЛТЫН ЗАХИАЛГАТ АЖИЛ



Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн байгууламжийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулж захиалагч байгууллагаас ирүүлсэн дээжний тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэн ч 2026 оноос туршилт шинжилгээний тоо буурах хандлагатай байна.

2025 оны хувьд Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын 29 байгууллагын 115 дээжид туршилт шинжилгээг гүйцэтгэн шинжилгээний хариуг хүргүүлэн ажилласан байна.

СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ОРЛОГЫН МЭДЭЭЛЭЛ



Лабораторийн туршилт шинжилгээний тарифыг шинэчлэн 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/122 дугаар Захирлын тушаалаар батлуулсан бөгөөд тухайн өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.



БУСАД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ

1. К-Смарт авто замын менежментийн систем (RMS) –д суурилсан улсын чанартай авто замын дижитал тогтолцоог хөгжүүлэх төслийн хүрээнд нийлүүлэгдэх Асфальтбетон хучилтын бүрэн шинжилгээ хийх хүчин чадал бүхий явуулын лабораторийг 2026 онд хүлээн авахаар бэлтгэж байна.

2. “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам”-аас №0000327 тоот дугаартай химийн хорт болон аюултай бодисыг ашиглах тусгай зөвшөөрлийг 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 5 жилийн хугацаатай аван ажиллаж байна.

Category	Design 1 (Proposed – Trailer)	Design 2 (Revised – Downsized Trailer)						
Figure								
	(Generator separated or integrated)	(Generator separated or integrated)						
	(Common) Tractor and trailer can operate independently from container(laboratory) after on-site installation ⇒ available for other purposes							
								
<Container(Laboratory)> < ① Tractor ② Tractor & Trailer ③ Trailer>								
Dimensions	• Total length : 17m				• Total length : 12m (negotiable)			
	Category	Length	Width	Height	Category	Length	Width	Height
	Tractor	6m	2.5m	3.9m	Tractor	6m	2.5m	3.9m
	Trailer	13m	2.5m	3.7m	Trailer	8m	2.5m	3.7m

2026 ОНД ХИЙГДЭХ ОНЦЛОХ АЖИЛ:

Авто замын төв лабораторийн итгэмжлэл нь 2026 оны 12 дугаар сард дуусах учир итгэмжлэл сунгуулахтай холбогдуулан баримт бичиг бэлтгэх, харьцуулсан туршилт хийх бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна.




ТЕХНИК АШИГЛАЛТЫН ТҮВШИН ТОГТООХ /ТАТТ/ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЭР






УЛСЫН ЧАНАРТАЙ ХАТУУ ХУЧИЛТТАЙ
АВТО ЗАМЫН ТЭГШ БУС БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ
(2025 он)




Үнэлгээ		2025 он		2024 он	
Маш сайн	IRI 0-2	22.43%	1480 км	22.95 %	1541.45 км
Сайн	IRI 2-4	45.25%	2985.1 км	42.88 %	2879.85 км
Дунд	IRI 4-6	20.11%	1335 км	21.52 %	1445.27 км
Муу	IRI 6-8	6.82%	450.8 км	7.8 %	523.59 км
Маш муу	IRI 8 <	5.39%	356 км	4.8 %	325.6 км







"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

2025 онд Олон улс,
улсын чанартай нийт **6730** км
хатуу хучилттай авто замд
хийж гүйцэтгэсэн ба үүний 3023
км -ыг ROMDAS системээр,
3807 км-ыг тэгш бус байдлын
үзүүлэлт буюу SSI техникээр,
нэр бүхий 15 гүүрэнд үзлэг
судалгаа хийж дүгнэлт тайлан
гаргаж ажиллаа.



Screenshot of the ROMDAS software interface showing a list of access objects and a table of data points.

Access Object	Object ID	Object Name	Object Type	Object Status	Object Location	Object Date	Object Time	Object Value	Object Unit
ROMDAS_Sensor	1	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	2	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	3	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	4	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	5	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	6	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	7	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	8	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	9	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0
ROMDAS_Sensor	10	ROMDAS_Sensor	Sensor	Active	100.0	100.0	100.0	100.0	100.0






АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

АВТО ЗАМЫН ТУХАЙ



11 дүгээр зүйл. Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг

11.1.9.авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн санг эрхлэн хөтөлж, нэгдсэн санг бүрдүүлж ажиллах

27 дугаар зүйл. Авто замын бүртгэл, мэдээллийн сан



2024-2025 ОНД ХҮЛЭЭН АВСАН АВТО ЗАМ, ГҮҮРИЙН ПАСПОРТЫН МЭДЭЭЛЭЛ







ХӨДӨЛГӨӨНИЙ ЭРЧМИЙН ТООЛЛОГО (ХЭТ), СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

“Улсын чанартай авто замуудад хийгдэх хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгааны ажлын даалгавар”-ыг боловсруулан, “АЗЗА нэгтэл”-тэй 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдөр 10 дугаартай “Улсын чанартай авто замуудад хийгдэх хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгааны ажил гүйцэтгэх гэрээ” батлагдсан.

2025 оны 5 удаагийн тооллогын дүнг сүүлийн гурван жилээр харьцуулсан графикыг дараах байдлаар харуулав.







“Авто зам – 2025” эрдэм шинжилгээний хурал





ТӨЛБӨР АВАХ ЦЭГ / ТАЦ /



Цахим төлбөр авах цэг - 12

Уламжлалт төлбөр авах цэг - 21

Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн бүтэц

- Хэлтсийн дарга -1
- Хэлтсийн мэргэжилтэн -10
- Төлбөр авах цэгийн ахлах -33
- Төлбөр авах цэгийн авто пүүний оператор - 195

2025 онд ашиглалтанд оруулах

- Айраг ТАЦ-д статик авто пүү суурилуулах динамик авто пүүг нүүлгэн шилжүүлэх ажлыг 07 дугаар сарын 24 ны өдөр хүлээн авч байнгын ашиглалтанд оруулсан.
- Дорноговь аймгийн Замын-Үүд төлбөр авах цэгийг авто замын хөрөнгөөр шинэчлэн засварлаж, нэмэлт хоёр статик авто пүү суурилуулсан.

Төлөвлөгөө

Төвлөрүүлэх
орлого
30.3 тб

Төвлөрүүлсэн
орлого
34,1 тб

Биелэлт
112.5%

2025 оны орлого төлөврүүлэлт

Орон нутаг орлого
12,1 тб

Цахим ТАЦ Орлого
22,06 тб

2025 оны давуулан биелүүлсэн орлого

3,752,278,076.4 төгрөг



Засгийн газрын 2016.02.15-ны өдрийн 103 тогтоол



Сүүлийн 4 жилийн орлого

2021	2022	2023	2024	2025
10 тб	13,5 тб	16,9 тб	26,7 тб	34,1 тб

2025 оны орлогын бүрдэл

- Авто замын хураамж – **11.4 тб**
- Транзит тээвэр – **616.7 сая**
- Задрах боломжгүй ачаа – **2.4 тб**
- Цахим – **19.5 тб**
- Нэвтрэх зөвшөөрөл - **24.5 сая**



2025 оны онцлох ажил Төлбөр авах цэгүүдийг цахимжуулах

- 2025 оны 04 дүгээр сараас 8 дугаар сарын 01 ний хооронд Хархорин Хужирт, Эрдэнэсант, Хангалын гүүр, Багануур Хэрлэн төлбөр авах цэгүүдийн үйл ажиллагааг дотоод нөөцөөр цахимжуулан ажилласан.
- Орон нутаг дахь 21 төлбөр авах цэгийг цахимжуулах “Олон улс, улсын чанартай авто замд RFID технологид хяналт тавих тоног төхөөрөмж суурилуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж төлбөр авах цэгүүдийн үйл ажиллагааг 2026 оны 05 дугаар сарын 01 өдрийн дотор бүрэн цахимжуулахаар төлөвлөн ажиллаж байна.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



Info@rtdc.gov.mn



7000-3706



“ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ”



<http://rtdc.gov.mn/>